

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН “ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 01

Өлгий хот

Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тус компани нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 34,560,651 төгрөгийн цэвэр ашигтай гарсан боловч 1,098,505,022 төгрөгийн дансны өглөгтэй, татварын албанд төлөх 570,459,829 төгрөгийн, нийгмийн даатгалын байгууллагад төлөх 18,874,779 төгрөгийн өртэй, банкнаас авсан урт хугацааны 3,477,987,863 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д заасан шаардлагыг хангахгүй байгаа тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосугай.

2. Энэ тухай хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдэхийг компанийн гүйцэтгэх захирал М.Тилеубердид үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.МАНЕН